



**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 05 сарын 29 өдөр

Дугаар А/ЗК

Хэрлэн сум

**Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын
газарт дэмжлэг үзүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Захиргааны ерөнхий хуулийн 10 дугаар зүйлийн 10.2, Хүүхийн эрхийг хамгаалах тухай хуулийн 17.1.2 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 23 дугаар хуралдааны “Аймгийн 2024 оны төсөв батлах тухай” 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газраас ирүүлсэн хүсэлтийн дагуу аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.4.9, Хүүхдийн хөгжил хамгааллын жилийн 2024 оны төлөвлөгөөний 4 дэх арга хэмжээг тус тус хэрэгжүүлэх ажлын хүрээнд Хүүхдийн эрхийг хамгаалах олон улсын өдрийг тохиолдуулан “Нэгдүгээрт хүүхэд” уриатай нөлөөллийн аян зохион байгуулах зардалд 12,000,000 (арван хоёр сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дэмжлэгт шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний “Хүүхдэд ээлтэй орон нутаг болно” зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н.Зоригтбаатар)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ